

үндсэн хөтөлбөр”-т тулгуурлан, бодитой үйл ажиллагаа явуулж үр дүнд хүрэх нь чухал болсоор байна. Энэ бүхнээс үзэхэд Монгол-Японы дипломат харилцааны хөгжлийн шинэ үе шат буюу стратегийн үе шат эхэлж буй хэмээн үзэх боломжтой юм.

Ашигласан эх сурвалж:

1. Н.Алтанцэцэг. Чингис хааны үнэлгээний талаарх гадаадын /орос, өрнөд, хятад/судлаачдын судалгаа, үзэл баримтлал - “Олон улсын харилцаа”сэтгүүл. №1 273(12). УБ.,2006
2. モンゴル最新ニュース国際、外交 2010年10月
3. 世紀日本外交の基本戦略 — 新たな時代、新たなビジョン、新たな外交 — 2011年11月
4. 最近のモンゴル情勢と日・モンゴル関係 2011年12月
蒙日外交・系及日本的用心 2008年
5. Н.Бадрал. Олон улсын харилцааны толь бичиг/Монгол, япон, хятад / УБ., 2008
6. Ж.Баясах. “Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал” (Түүвэр зохиол) УБ., 2010
7. Ч.Далай нар. “Монгол, японы харилцаа: эрт, эдүгээ” Ред. Ц.Батбаяр, Ц.Төмөрхүлэг УБ.,2001
- 8.Т.Намжим .Монгол Японы түншийн харилцаа УБ 2010
- 9.Д.Цолмон. “Дипломат ёс горим төрийн ёслолын уламжлал, шинэчлэлийн зарим асуудал”-//”Олон улсын харилцаа”-сэтгүүл.№1 УБ.,2006.
10. ”Олон улсын харилцаа” сэтгүүл № 1 УБ., 2006
- 11.Тора Асо Эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум: Япон улсын өргөжин хөгжиж буй дипломат үйл ажиллагааны хүрээ-Олон улсын харилцаа// сэтгүүл.№1. УБ., 2006.х.136-144
- 12.Л.Хайсандай “Олон улс судлалын өгүүллүүд” УБ. 2003
- 13.Бусад эх сурвалж

ЯПОНЫ СОЁЛЫН ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНЫ ТҮҮХЭН ТОЙМ, ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА

Д.Оюунцэцэг^{1*}

Оршил

Дэлхийн улс орнуудын гадаад бодлогод чухал байр суурийг нэгэнтээ эзлэх болсон соёлын дипломат ажиллагааг улс төр судлаач, эрдэмтэн Мильтон Каммингс “хоёр талын ойлголцлыг хөгжүүлэх зорилгоор хамт олны дунд санаа бодол, мэдээлэл, урлаг, амьдралын хэв маяг, үнэт зүйлсийн систем, уламжлал, итгэл үнэмшил хийгээд бусад соёлын зүйлсийг солилцох явдал² гэж тодорхойлсон байдаг.

1990-ээд оноос эхлэн онолын түвшинд гарч ирсэн соёлын дипломат ажиллагааг улс орнууд үндэстэн хоорондын харилцан хамаарал гүнзгийрсэн даяаршлын эрин үед гадаад бодлогынхоо салшгүй хэсэг хэмээн үзэж, гадаад бодлогод өргөн ашиглах болсон байна. Улс орнууд энэхүү ажиллагааг идэвхтэй явуулах нь улс үндэстэн хоорондын харилцаанд харилцан ойлголцох найрсаг уур амьсгалыг буй болгож, хоёр орны харилцаа төдийгүй олон улсын харилцаанд байр сууриа бэхжүүлэх, нэр хүндээ өсгөх зэрэг олон талын ач холбогдолтой билээ.

Соёлын дипломат ажиллагааны онцлог, үүрэг, ач холбогдол, арга ажиллагаа зэргээс нь дүгнэн соёлын дипломат ажиллагааг өөрийн давуу тал хийгээд бусад орны ард түмэнд хамгийн өргөн хүрээтэйгээр хүрч чадах соёлын элементүүдийг ашиглан, ард түмний хоорондын харилцааг ойртуулж, харилцан ойлголцол, итгэлцлийг бий болгох замаар гадаад бодлогын таатай орчинг бүрдүүлэх зорилго бүхий дипломат ажиллагааны нэг хэлбэр хэмээн тодорхойлж болох юм. Соёлын дипломат ажиллагааг нь эдийн засгийн, улс төрийн, олон нийтийн гэх мэт бусад дипломат ажиллагааны хэлбэрүүдтэй хослон явуулахад илүү их ач холбогдолтой байдаг.

Орчин үед соёлын дипломат ажиллагааг амжилттай явуулж буй улс орнуудын дотроос Япон улс нь дэлхийн олон улс орнуудыг хамарсан, өргөн цар хүрээтэй, харилцан туслалцсан соёлын дипломат ажиллагааг явуулдагаараа онцлог юм.

1. Японы соёлын дипломат ажиллагааны түүхэн тойм

Японы орчин үеийн түүхэнд XIX зууны сүүлчээс эдүгээ хүртэлх үеийг багтаадаг. Эх газрын орон болохыг санаархан милитарист шинжтэй бодлого явуулж, Их Британи, Франц, Итали зэрэг Европын улс орнуудтай цэргийн эвсэл холбоонд нэгдэн гэрээ хэлэлцээр байгуулж байсан дэлхийн I дайны үеэс Японы гадаад бодлогод Европын дипломат хэв маяг нэвтэрсэн гэж үздэг байна.

1920-иод оны сүүлч үе, 1930-аад оны эхэн үеэс гадаад бодлогодоо соёлын харилцаа тэр

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

² Cummings.M, Cultural Diplomacy and the United States Government: A survey. Center for Arts and Culture, 2003, p.1.

дундаа соёлын ухуулга сурталчилгааг ашиглах болсноор Японы соёлын дипломат ажиллагааны эхлэл тавигдсан бол найрсаг харилцаа, хамтын ажиллагаан дээр тулгуурласан орчин үеийн соёлын дипломат ажиллагаа нь 1960-аад оны үеэс төлөвшиж эхэлжээ.

Судлаачид Японы соёлын дипломат ажиллагааг дараах үе шатуудад хувааж үздэг байна.

Дэлхийн I дайны дараах үе.

Дэлхийн I дайны дараагаас Япон улсын Засгийн Газар цэрэг, улс төрийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх, нэр хүндээ сэргээх, хурцадмал байдлыг зөөлрүүлэх зэрэгт соёлын сурталчилгаа явуулж байсан нь соёлын дипломат ажиллагааны эхлэл болсон билээ. 1920 оны 4-р сард /албан ёсоор бол 1921 оны 8-р сар/ Гадаад Хэргийн Яам гадаад дотоодын мэдээлэл цуглуулах, Японы талаар сурталчилгаа явуулах үүрэг бүхий мэдээллийн хэлтсийг, 1923 онд Япон Хятдын соёлын асуудлыг хариуцсан соёлын хэлтсийг тус тус байгуулжээ. Хятад дахь Японыг эсэргүүцсэн тэмцэл ширүүсэнтэй холбогдуулан Японы Засгийн Газраас соёл, боловсролын салбар дахь хамтын ажиллагаагаар дамжуулан Хятад, Японы харилцааг зөөлрүүлэхийг хичээж, олон зуун залуучуудыг Японд суралцуулах болсон бөгөөд түүний дотор Өвөр Монгол гаралтай хүмүүс цөөнгүй байсан байна.³

1931 оны Манжуурыг довтлон эзэлсэн явдал, 1933 оны 3-р сард Үндэстнүүдийн холбооноос гарсан асуудал зэргээс шалтгаалан олон улсын тавцанд нэр хүнд нь муудаж, ганцаардах хандлагатай болсон Японыг гадаад ертөнцтэй дахин холбох гүүр бол соёлын харилцаагаар дамжуулсан ухуулга сурталчилгаа байлаа. 1934 оны 4-р сарын 11-нд Японы Засгийн Газар олон улсад Японыг сурталчлах зорилго бүхий соёлын үйл ажиллагаа зохион байгуулан явуулах “Соёлыг дэмжих олон улсын нийгэмлэг”-ийг байгуулав. Тус байгууллага нь 1) Японы талаарх мэдээлэл сурталчилгаа бэлтгэж, түгээх; 2) гадаадын соёлын байгууллага, соёлын салбарын алдартнуудтай хамтран ажиллах; 3) багш, оюутан харилцан солилцох; 4) лекц уулзалт, үзэсгэлэн зохион байгуулах; 5) ном, сурах бичиг орчуулах, хэвлэх; 6) гадаад орнуудад япон сургууль, дорно дахин судлалын төв байгуулахад дэмжлэг үзүүлэх; 7) кино, дэлгэцийн бүтээлд санхүүжилт үзүүлэх зэрэг өргөн цар хүрээ бүхий олон талт соёлын үйл ажиллагаа явуулдаг байжээ. Уг байгууллага нь Японы Гадаад Хэргийн Яамнаас санхүүждэг байсан бөгөөд 1934 онд 200 мянга, 1937 онд 340 мянга, 1939 онд 500 мянга, 1940 онд 700 мянган иеныг үйл ажиллагаандаа зарцуулсан баримт байна.⁴

Өрнөдөд унасан нэр хүндээ сэргээхэд Их Британи, Герман, Итали, Франц зэрэг орнуудын мэдээллийн төв болсон Нью-Йорк хотод соёлын төв нээх шаардлагатай гэдгийг ухаарч “Соёлыг дэмжих олон улсын нийгэмлэг” нь 1938 оны 11-р сард Японы Соёлын Төвийг Нью-Йорк хотод байгуулав. Тус төв үндсэндээ мэдээллийн үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд номын сан нээж, радио, сонин хэвлэл, танилцуулга “Япон орноор аялахуй”, баримтат кино, гэрэл зургаар дамжуулан Японы гадаад дотоод бодлогыг таниулан сурталчилж Америк дахь соёлын байгууллагуудтай хамтран ажиллаж байв.⁵ 1940 онд Гадаад Хэргийн Яамны мэдээллийн хэлтсийг Засгийн Газрын дэргэдэх Мэдээллийн Товчоо болгон өргөтгөж, Японы талаарх мэдээлэл сурталчилгаа бүхий радио нэвтрүүлэг бэлтгэн гадаад дотоодод цацах болов.

³ 金子将史。パブリックディプロマシー。PHP研究所。東京。2007年。p. 185-186

⁴ Sang Mi Park. *Wartime Japan's Cultural Diplomacy and the Establishment of Culture Bureaus*. WIAS Discussion Paper, No 2008-2009, p. 7-8

⁵ Sang Mi Park. *Wartime Japan's Cultural Diplomacy and the Establishment of Culture Bureaus*. WIAS Discussion Paper, No 2008-2009, p. 15

Дэлхийн I дайны дараах үеийн Японы соёлын дипломат ажиллагаа соёлын харилцаанд тулгуурласан ухуулга сурталчилгаа хэлбэрээр явагдаж байсан гэж үзэж болно.⁶

Дэлхийн II дайны дараагаас 1970 он

Дайны дараах Японы гадаад бодлогод өөрчлөлт орж энх тайванч, ардчилсан “соёлт улс”-ыг байгуулах, олон улсын тавцанд өөрийн байр сууриа олж авах, бэхжүүлэхэд чиглэж байв. Тиймээс ч 1950, 60-аад оны Японы соёлын дипломат бодлогын үндсэн зорилго нь түрэмгийлэгч, милитарист орон хэмээх нэр хочноосоо салж, энх тайванч ардчилсан улс хэмээх шинэ имижийг бүрдүүлэхэд оршиж байлаа. Олон улсын тавцан дахь өөрийн байр сууриа сэргээхийн тулд хийсэн анхны томоохон алхам бол 1951 онд Сан-Францискогийн энх тайвны гэрээнд нэгдэн орж, мөн ЮНЕСКО-гийн албан ёсны гишүүн болсон явдал юм.⁷

Ингэснээр энх тайванч ардчилсан Япон улсын үндэсний онцлог, шинэ дүр төрхийг олон улсын соёлын хамтын ажиллагаагаар дамжуулан гадаад орнуудад сурталчлан таниулах боломж нээгдсэн ба Засгийн Газрын зүгээс цайны ёслол, “икэбана” хэмээх цэцгийн урлал зэрэг цөөн тооны үндэсний уламжлалыг сурталчлахыг чухалчилж байв. Хэвлэл мэдээлэлд онцгой ач холбогдол өгч, японы гадаад харилцааны бодлого, улсын дотоод байдал, бодлогын чанартай асуудлуудыг тусгасан тогтмол хэвлэл, ном товхимол, эмхэтгэл, мөн түүнчлэн японы үндэсний уламжлал, байгалийн сайхныг дүрсэлсэн зурагт хуудас, хуанли, ил захидал зэргийг олноор хэвлэн гадаад орнуудад тарааж байлаа.

1960-аад оны дунд үеэс 1970-аад оны эхэн үе гэхэд Японы эдийн засаг үсрэнгүй хөгжиж өндөр хөгжилтэй хүчирхэг орнуудын нэг болсноор (эдийн засгийн үзүүлэлтээрээ 1966 онд капиталист хэмээгдэж байсан орнуудын дотор 5 дугаарт, 1968 онд хоёрдугаарт бичигдэж байв⁸) соёлын дипломат ажиллагаанд илүүтэй ач холбогдол өгч, олон улсын соёлын үйл ажиллагаанд анхаарлаа хандуулах болсон байна. 1964 онд Токио хотноо Олимпийн наадам, 1970 онд Осака хотноо олон улсын үзэсгэлэн буюу ЭКСПО-г амжилттай зохион байгуулсан нь дэлхий дахинаа “Энх тайванч Япон” хэмээх шинэ дүр төрх хийгээд эдийн засаг, техник технологийн хөгжлийг хамтад нь харуулж чадсан өндөр ач холбогдолтой арга хэмжээнд тооцогдох болж Японы гадаад дахь нэр хүнд, байр суурийг дээшлүүлэх чухал алхам болсон юм. Түүнээс хойш олон улсын чанартай соёл хүмүүнлэг, урлаг спортын олон талт арга хэмжээ шил дараалан зохион байгуулах болсон билээ.

1964 онд Гадаад Хэргийн Яаманд Эдийн засгийн хамтын ажиллагааны газрыг шинээр, 1968 онд Соёлын газрыг дахин шинэчилэн байгуулсан нь соёлын дипломат ажиллагаа, эдийн засагтай нягт холбоотой хөгжихөд гол түлхэц болсон билээ.

Харин 1970-аад оны эхэн үеийг хүртэл япон хэлийг гадаадад сурталчлах арга хэмжээ харьцангуй бага явагдаж байсан нь япон хэлийг Азид түгээх дайны өмнөх үеийн бодлого (тухайлбал, Солонгос, Хятад улсад япон хэлийг заавал сурахыг тулгаж байсан) -ынх нь үргэлжлэл, эзлэн түрэмгийлэх санаархал хэмээн хүлээж авах магадлал өндөр байсантай холбоотой байжээ.

Энэ үеийг Японы соёлын дипломат ажиллагааны хөгжлийн эхэн үе, дэлхий дахинд шинэ Япон орныг сурталчлан таниулах анхны алхмууд амжилттай хэрэгжиж, олон улсын тавцан дахь байр сууриа сэргээсэн үе хэмээн дүгнэж болно.

⁶ Зарим судлаачид энэ үеийг Японы соёлын дипломат ажиллагааны хөгжлийн үед тооцдоггүй байна.

⁷ 金子将史。パブリックディプロマシー。PHP研究所。東京。2007年。p.187

⁸ 채선영, 일본 문화외교에 관한 연구: 국제교류기금을 중심으로, 한신대학교 대학원 석사학위 논문. p.13

1970-1980 он

Японы эзэн хааны АНУ болон Европт хийсэн айлчлал нь хааны гэр бүлийн гадаад харилцааг нээж, соёлын дипломат бодлого Америк, Европ руу чиглэхэд түлхэц өгчээ. Олон улсын соёлын харилцааг хэрэгжүүлэх олон нийтийн байгууллага болох “Япон сан” (Japan Foundation) -г байгуулж, “албан ёсны соёлын экспорт” хийх болсон энэ үеэс л Японы соёлын дипломат бодлогын үндсэн хэв маяг бүрэлдэж ирсэн гэж үздэг.⁹

Милитарист гүрэн хэмээх нэр хочноосоо салж, олон улсын нийгэмлэгт өөрийн байр сууриа олж авч чадсан Японы соёлын дипломат ажиллагааны бодлогыг шинэчлэх, олон улсын шинж чанартай болгох шаардлагатай гэж үзээд 1972 оны V сард Японы сангийн тухай хууль батлагдаж, мөн оны X сард Гадаад Хэргийн Яамны Соёлын Газрын шууд удирдлага дор Япон улсын гадаад бодлогыг хилийн чанадад сурталчлан таниулах үйл ажиллагаа явуулах “Япон сан”-г байгуулав. Тус сангийн үндсэн зорилго нь экспортыг нэмэгдүүлэх замаар эдийн засгаа хүчирхэгжүүлэх Засгийн газрын бодлогыг амжилттай хэрэгжүүлэх үүднээс Японы талаарх гадаадынхны буруу ойлголтыг засаж залруулах, үнэн бодит мэдээллээр хангахад оршиж байлаа.¹⁰

Анхлан жилийн 20 тэрбум иений төсөвтэй (цаашид 50 тэрбум хүртэл өссөн)¹¹ “Япон сан” олон улсын соёл боловсролын хамтын ажиллагааг хөгжүүлэх, боловсон хүчний солилцоо явуулах, хилийн чанад дахь япон хэлний боловсролыг дэмжих байгуулах, япон судлалыг хөгжүүлэх, япон орны түүх соёлыг сурталчлан таниулах, соёл урлагийн байгууллагуудад хандив тусламж үзүүлэх, урлаг соёлын тоглолт, үзэсгэлэн, наадам зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулж байлаа. Ялангуяа Америк, Их Британи гэх мэт гол түншлэгч орнууддаа соёл мэдээллийн төв байгуулан олон талт соёлын үйл ажиллагааг идэвхтэй явуулж, иргэд хоорондын харилцаанд анхаарал тавин, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж эхэлсэн байна.¹²

Харин Азид, тэр дундаа Зүүн өмнөд Азид явуулж байсан хэт нэг талыг барьсан эдийн засгийн дипломат ажиллагаа эсэргүүцэлтэй тулгарах болсныг ерөнхий сайд Танака Какүэйгийн 1974 оны I сард Тайланд, Индонезид хийсэн албан ёсны айлчлалын үеэр болсон үймээн харуулсан юм.¹³ Ийнхүү үүсээд байсан тааламжгүй нөхцөл байдлыг зохицуулах, харилцаагаа хэвийн болгохын тулд нүүр тулан харьцах шаардлагатай болсон ба үүнд мөн л соёлын дипломат ажиллагаа ивүүр болох хэрэгтэй байлаа. Зүүн өмнөд Азийн хөгжиж буй орнуудад соёл боловсролын тусламжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн ба 1975 оноос Зүүн Өмнөд Ази дахь соёлын үнэт өв, өв уламжлалыг хамгаалах, сэргээн засварлах соёлын буцалтгүй тусламж үзүүлэх болсон. 1978 онд АСЕАН-ы орнуудтай соёлын хамтын ажиллагаа явуулах зорилгоор “АСЕАН- Соёлын сан” байгуулж, 5 тэрбум иен хандивлав.¹⁴ Улсын төдийгүй сайн дурын байгууллага болон төрийн бус байгууллагууд ч энэ талбарт өргөн хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. 1977 оны 8-р сард сард ерөнхий сайд Фүкүда Такеогийн зарласан Зүүн Өмнөд Азитай харилцах гадаад бодлого (Фүкүда доктрин) нь тус бүс нутагт Японы соёлын дипломат ажиллагаа улам бүр эрчимтэй хөгжихөд түлхэц үзүүлсэн юм.

⁹ 金子将史, パブリックディプロマシー, PHP研究所, 東京. 2007年, p. 189-193

¹⁰ Peter J. Katzenstein, *Open Regionalism: Cultural Diplomacy and Popular Culture in Europe and Asia*, The American Political Science Association Annual Meeting Paper, 2002, p.14

¹¹ Kazuo Ogoura, *Japan's Postwar Cultural Diplomacy*, Center for Area Studies, Working Paper No1, 2008, p.2

¹² 金子将史, パブリックディプロマシー, PHP研究所, 東京. 2007年, p. 189-193

¹³ Nancy Snow, Philip M. Taylor, *Routledge handbook of public diplomacy: Origin and Development of Japan's Public Diplomacy*, New York, 2009, p.275

¹⁴ Nancy Snow, Philip M. Taylor, *Routledge handbook of public diplomacy: Origin and Development of Japan's Public Diplomacy*, New York, 2009, p.275

1975 оноос Гадаад Хэргийн яамнаас “Гадаад харилцааны эмхэтгэл” гэдэг товхимолыг гаргах болсон нь сурталчилгааны томоохон бүтээгдэхүүн болж байв.

Японы соёлын дипломат бодлогыг хэрэгжүүлэгч үндсэн байгууллага болох “Япон сан” байгуулагдаж, Америк, Их Британи мэтийн гол түншлэгч орнууд төдийгүй Азийн хөгжиж буй орнуудад анхаарлаа хандуулах болж, соёлын буцалтгүй тусламж үзүүлэх болсон нь олон улсын тавцанд Японы нэр хүнд өсөхөд чухал үзүүлэлт болсон юм.

1980-1990 он

1980- 90 –ээд оны үе бол Японы соёлын дипломат ажиллагааны өсөлт хөгжлийн үе юм. Эдийн засгийн өндөр хөгжлийнхөө ачаар өөртөө бат итгэлтэй болсон, олон улсын тавцан дахь нэр хүндээ өсгөж чадсан, олон улсын хамтын нийгэмлэгүүдийн хариуцлагатай түнш, гол хандивлагч орон нь болсон Япон улсын гадаад бодлогын үзэл баримтлал нь “Энхтайвныг хамгаалах олон улсын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулах”, “Засгийн Газрын хөгжлийн тусламж буюу эдийн засгийн тусламж үзүүлэх”, “Соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх” гэсэн гурван тулгуур бодлогоор дамжин хэрэгжиж байв. Энд дурдсан “соёлын хамтын ажиллагаа” нь жинхэнэ утгаараа Японы соёлын дипломат ажиллагааны үүргийг гүйцэтгэж байлаа.

“Япон сан”-гаас урьд өмнө хэрэгжүүлж байсан олон талт үйл ажилагаа, түүнээс гадна хөгжиж буй улс орнуудын соёлын салбарын хөгжилд тусламж үзүүлэх зорилгоор театр, урлагийн тайзны гэрэл чимэглэл, бичлэгийн тоног төхөөрөмжөөр хангах, музей үзэсгэлэнгийн танхимуудыг тохижуулах, урлаг соёлын үйл ажиллагаанд техникийн тусламж үзүүлэх зэрэг арга хэмжээ соёлын хамтын ажиллагаанд багтаж байв.

“Дэлхийн соёлын хөгжилд хувь нэмэр оруулах” Японы бодлого бодитоор хэрэгжиж эхэлсний нэг жишээ нь 1985 онд Япон улсын Засгийн Газраас ЮНЕСКО-гийн дэргэд Японы санхүүжилтээр дэлхийн соёлын өв сан, ялангуяа хөгжиж буй орнууд дахь соёлын өв санг хадгалан, хамгаалах, сэргээн босгох ажилд тусламж үзүүлэх зорилготой “Соёлын өв санг хадгалан, хамгаалах “Япон сан”” –г байгуулсан явдал юм.¹⁵

80-аадоны дунд үе гэхэд Япон машин, гэрэхуйн цахилгаан бараа, бусад бараа бүтээгдэхүүнүүд Азийн зах зээлийг эзэлж байсан хэдий ч тэдний нүдэнд үл харагдах япончуудыг “иены цаана нүүрээ нуусан үл үзэгдэгчид”, “Азийг зоосны нүхээр харагчид”, “Азид зөвхөн эдийн засгийн сонирхлоор л ханддаг” хэмээн шүүмжлэх явдал үргэлжилсээр байсан тул Япончуудын талаар зөв ойлголт төрүүлэх, нэр хүндийг сэргээх үүргийг мөн л соёлын дипломат ажиллагаа гүйцэтгэх болов.¹⁶ 1989 онд “Япон сан” Токио хотноо Япон болоод Азийн орнуудыг харилцан сурталчлах, тэдний харилцан ойлголцлыг дэмжих зорилготой “АСЕАН- Соёлын төв”-ийг байгуулан ажиллажээ. Тус төв нь Ази дахь Японы талаарх ойлголтыг дээшлүүлэхийн тулд төрөл бүрийн боловсролын болоод соёлын солилцооны хөтөлбөрүүдийг санхүүжүүлж, Азийн олон орны урлагийн одод, дуучид, жүжигчдийн хамтарсан тоглолт, жүжиг, кино зэргийг ивээн тэтгэх үйл ажиллагаа явуулснаар Ази дахь Японы талаарх таагүй ойлголтыг засаж залруулаад тогтохгүй Ази дахь Японы оролцоог хүлээн зөвшөөрүүлж чадсан байна.

1990- 2000 он

Даяаршлын эрин үе Японы гадаад бодлого, соёлын дипломат ажиллагааны чиг хандлагад нөлөө үзүүлж, шинэ үе шатанд хүргэлээ.

¹⁵金子将史。パブリックディプロマシー。PHP研究所。東京。2007年。p.194-197

¹⁶ Kazuo Ogoura, *Japan's Postwar Cultural Diplomacy*, Center for Area Studies, Working Paper No1, 2008, p.4

1990 оны Ирак- Кувейтын дайны үеэр төвийг сахисан байр суурьтай байж, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцохоос татгалзсанд дургүйцсэн улсуудын шүүмжлэл, Америк болон Европын орнуудтай хийсэн гадаад худалдааны үр дүнгээс үүдсэн Японы талаарх тааламжгүй ойлголт гэх мэт олон улс хүрэн дэхь сөрөг асуудлыг зохицуулахын тулд соёлын дипломат ажиллагааны шинэ чиг хандлагыг эрэлхийлэх шаардлагатай болов.¹⁷

Хөгжингүй, ардчилсан улс үндэстнүүдийн хамтын нийгэмлэгт бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн, өндөр итгэл хүлээсэн хариуцлагатай түнш байх хэтийн зорилт тавьсан Японы Засгийн Газар 1992 онд өндөр хөгжилтэй орнуудтай түншлэл тогтоох олон улсын хамтын нийгэмлэг болох Дэлхийн Түншлэлийн Төв (Center for Global Partnership) хэмээх байгууллагыг 50 тэрбум иений төсөвтэйгээр байгуулж АНУ болон бусад хөгжингүй орнуудтай хамтран өргөн цар хүрээтэй оюуны болоод соёлын хөтөлбөрүүд, хөгжиж буй орнуудын ардчилалыг дэмжих, хүрээлэн буй орчны асуудал, халдварт өвчин зэрэг тулгамдсан асуудлуудаар хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн¹⁸ нь олон нийтийн болоод соёлын дипломат ажиллагаа шинэ шатанд гарах эхлэл болж өгсөн юм.

Нөгөө талаар даяаршлын нөлөөгөөр Хятад, Өмнөд Солонгосын эдийн засаг хурдацтай хөгжиж, соёлын дипломат бодлого явуулж эхэлснээр дэлхий дахин Японыг ардчилсан, эдийн засгийн өндөр хөгжилтэй, эртний түүх соёлт Азийн бусад орнуудтай харьцуулах болж, Японы “өвөрмөц” имиж суларч эхлэв. Азийн улс орнууд Японыг эдийн засгийн тэргүүлэх орон, даган замнах ёстой загвар улс мөн эсэхэд эргэлзэхэд хүрэв. Тиймээс Японы соёл дипломат ажиллагаа Азийн бусад орнуудаас эрс өөр, илт ялгарахуйц Японы дүр төрхийг дахин гаргаж ирэх хэрэгтэй болсон байна.

Японы уламжлалт соёлын өвөрмөц талуудыг онцлохоос илүүтэй орчин үеийн урлагт анхаарлаа хандуулах болж, “анимэшн” буюу хүүхэлдэйн кино, “манга” хэмээх зурагт цуврал ном, хувцас загвар, поп дуу хөгжим, үндэсний хоол, залуу зохиолчдын бүтээлүүд, телевизийн олон ангит цуврал зэрэг орчин үеийн урлагийн төрлүүдээр шинэ имижийг бүрдүүлэн түүгээрээ дамжуулан бусад орны иргэд, залуу үеийнхэнд өөрийн орны түүх өв уламжлал, хүмүүсийн амьдрал ахуй, орчин үеийн техник технологийн хөгжил, соёл урлагийн талаар ойлголт, мэдлэг олгож, Японд зочлох, суралцах хүсэл эрмэлзэл төрүүлэх болжээ. Өсвөр үеийнхэн, хүүхэд залуучуудын хүсэл сонирхол дээр тулгуурлан “Япон сан”-гийн санхүүжилтээр япон хэл, соёлын төрөл бүрийн дугуйлан, соёлын төвүүдийг ажиллуулж, тодорхой хөтөлбөрүүд хэрэгжүүлж эхэлжээ.

Мөн түүнчлэн дээр дурдсан орчин үеийн урлагийн төрлүүдийг дагаад Японы соёлын дипломат ажиллагаанд соёлын бүтээгдэхүүн үйлдвэрлэл буюу контент үйлдвэрлэл, контент худалдааны бодлого, зохиогчийн эрх, оюуны өмчийг хамгаалах зэрэг үйл ажиллагааны шинэ чиглэлүүд орж ирэв.

Гадаад Хэргийн яам өөрийн цахим хуудастай болсон нь Японы гадаад дотоод бодлого, япон улс, япон иргэдийн талаарх бүхий л мэдээллийг дэлхийн өнцөг булан бүрт түгээх сайхан боломж олгосон бол NHK телевиз бэлтгэсэн нэвтрүүлгээ олон улсын сувгаар англи хэлээр цацах болсноор Япон орны талаарх бүхий л талын дүрст мэдээллийг дэлхий дахин шуурхай хүлээн авах боломжоор хангагдсан юм.¹⁹

¹⁷金子将史。パブリックディプロマシー。PHP研究所。東京。2007年。p.197

¹⁸ Kazuo Ogoura, *Japan's Cultural Diplomacy: Past and Present*, JRIPEC, 2009, p.48

¹⁹金子将史。パブリックディプロマシー。PHP研究所。東京。2007年。p.197—200

1990-2000 он хүртэлх Японы соёлын дипломат ажиллагааны цар хүрээ өргөжин, олон улсын хамтын нийгэмлэгүүдтэй хамтран ажиллаж, бүс нутаг болоод дэлхий дахины тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд голлох үүрэгтэй оролцох болсон бол үндэсний өвөрмөц онцлогийг тусгасан гэхээсээ техник технологийн хөгжилд тулгуурласан орчин үеийн урлагаар илэрхийлэгдэх Японы шинэ дүр төрхийг бүрэлдүүлснээрээ гадаад орны хүүхэд залуусыг татаж чадсанаараа онцлог юм.

2. Японы орчин үеийн соёлын дипломат ажиллагаа, өнөөгийн чиг хандлага

Шинэ зууны эхэнд буюу 2000 онд Японы ерөнхий сайд Обучи Кейзогийн зарласан “XXI зууны хөгжлийн бодлого” хөтөлбөрт “Япончуудын мэргэжлийн чадвар, авъяас билэг, боломжийг дээд зэргээр ашиглан, дэлгэрүүлэх нь Япон улсын ирээдүйг шийдэх болно гээд эдийн засгийн хөгжлийн хурд саарч байгаа Японы хувьд зөөлөн хүчийг ашиглах нь чухал” болохыг дурдсан байна.²⁰ Ийнхүү Засгийн Газрын зүгээс соёлын дипломат ажиллагааны үүрэг, ач холбогдлыг чухалчлан үзэж, урьд урьдаас илүү анхаарлаа хандуулах болсон ба үеийн үеийн ерөнхий сайд нар соёлын дипломат ажиллагааг тууштай дэмжин ажиллаж ирсэн билээ. Тухайлбал Ерөнхий сайд Коизуми Жүничиро Япон улсын хувьд соёлын бодлого бол эдийн засгийн гадаад бодлогын нэгэн адил чухал зүйл²¹ гэж үзээд шинжлэх ухаан технологийн салбарт соёлын дипломат ажиллагааг түлхүү хөгжүүлэхийг сайшааж байжээ. Түүний удирдлагаар 2004 онд Гадаад Хэргийн Яаманд гадаад сурталчилгаа болон олон улсын соёлын харилцааны асуудлыг хавсран хариуцах “Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газар” (англи хэлээр Public Diplomacy Department гэж орчуулагддаг байна ²²) байгуулагдсан байна. Мөн түүнчлэн Ерөнхий сайдын удирдлага дор нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөх комисс байгуулагдаж Японы соёлын дипломат ажиллагааны бодлогыг томъёолон боловсруулах асуудлыг 2004 оны XII сараас 2005 оны VII сар хүртэл хэлэлцэн зөвлөлдсний эцэст “Соёлын харилцааг эрхэмлэсэн энх тайванч улс - Япон брэнд” хэмээх бодлогыг баталсан байна. Уг бодлогын баримт бичигт Японы соёлын дипломат ажиллагааны үндсэн гурван зарчмыг тодорхойлсон ба үүнд :

Илгээх : Соёлыг илгээх XXI зууны брэнд буюу загвар болох “Cool Japan”

Хүлээн авах : Гадаадын соёлыг хүлээн авч, дэмжих

Зэрэгцэн орших : Олон соёл болоод үнэт зүйлсийн хооронд гүүр болох²³ багтана.

XXI зууны Японы брэнд – “Cool Japan” гэдэг нь Японы манга, анимэшн, компьютер тоглоом, кино, телевизийн цуврал, “J-pop” буюу орчин үеийн дуу хөгжим, J-fashion буюу хувцас загвар зэрэг олон нийтийн соёл болоод орчин үеийн урлаг, уран зохиол, тайз дэлгэцийн бүтээлүүдийг нийтэд нь нэрлэж байгаа бөгөөд энэхүү соёлыг хүлээн авагчдын ихэнх нь гадаад орны хүүхэд залуус юм.

“Сүүлийн үед “Cool Japan” буюу Японы соёлын бүтээгдэхүүнүүд дэлхий дахины анхаарлыг ихэд татаж байна. Японы талаарх гадаадынхны сонирхлыг өсгөн нэмэгдүүлэх, Японы нэр хүндийг олон улсын тавцанд өсгөхийн тулд Гадаад Хэргийн Яам хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаараа дамжуулын хувийн секторуудтай хамтран ажиллаж байгаа

²⁰ 이수진, 패전이후 일본의 문화외교 전략성에 관한 연구-국제교류기금을 중심으로, 한양대학교 국제학대학원 國際學院友論集 8集 (2011) p.157

²¹ www.mofa.go.jp

²² <http://www.mofa.go.jp/about/hq/chart.html>

²³ 佐々木 隆, 第16回 文化外交とは何 p. 2 <http://www.econfn.com/ssk/>

байгаа бөгөөд “Япон сан” улс орон бүрийн онцлогийг харгалзан үзэж, зохистой болоод таатай соёлын солилцоог сурталчлан явуулж байгаа билээ²⁴ хэмээн 2006 оны “Дипломатын хөх ном”-д бичсэн байна.

2006 оны IV сард Гадаад Хэргийн сайд Асо Таро Дижитал Холливуд Их сургуулийн оюутнуудад Японы Засгийн газраас явуулж буй соёлын дипломат бодлогын талаар уншсан лекцдээ дипломат ажиллагаанд соёлыг татан оруулах, бүрэн ашиглахын чухлыг онцлон тэмдэглэхийн зэрэгцээ японы поп соёл, түүний дэлхий дахинд хэрхэн амжилттай түгэн дэлгэрч буйг дурдаад “МАНГА дээд шагнал” бий болгох, шалгарсан шилдэг бүтээлийг гадаад Япон орныг сурталчлах “Анимэ элчин сайд” төслийн талаар оюутан сурагчдад танилцуулжээ.²⁵

ГХЯ-ны санаачлагаар 2007 оны V сард “Олон улсын МАНГА дээд шагнал” хэмээх арга хэмжээг зохион байгуулахад 26 орны 146 бүтээл оролцож байсан бол өнгөрсөн жилд болсон 4 дэхь удаагийн уралдаанд 39 оны 189 бүтээл оролцох болсон нь тэмцээний цар хүрээ өргөжин тэлж байгааг харуулж байна.²⁶

Дараагийн нэг томоохон арга хэмжээ бол дээр дурдсан “Анимэ элчин сайд” төсөл нь анимэшнээр дамжуулан Японыг сонирхох сонирхлыг нэмэгдүүлэх зорилготой юм. 2008 оны 3-р сард Гадаад Хэргийн сайд Коумура “Доразмон” хэмээх хүүхэлдэйг Японы Анимэ элчин сайдаар өргөмжлөн гэрчилгээ гардуулсан юм. “Доразмон” хүүхэлдэйн кино нь англи, франц, испани, хятад, орос гэсэн 5 хэлээр орчуулагдан дэлхийн 65 хотод нээлтээ хийн, шоу арга хэмжээ зохион байгуулахад ойролцоогоор 27 мянган хүн оролцсон байна.²⁷

2009 оны II сард поп соёлын салбарт, тэр тусмаа загварын салбарт идэвхтэй ажиллаж, амжилт гаргаж буй залуус Японы Поп соёлын чиг хандлагыг тодорхойлогч буюу “каваи элчин сайд”-аар сонгогдсон ба тэдэнд Япон улсаас гадаад улсад суугаа ЭСЯ болон Японы сангаас хамтран зохион байгуулж буй соёлын төсөл хөтөлбөрүүдэд хамтран ажиллах замаар сурталчилгаа болон бусад арга хэмжээг зохион байгуулах бүрэн эрх олгож байна.

Энэ мэтчилэн жилээс жилд шинэ шинэ урлагийн төрөл, олон улсын чанартай арга хэмжээ, хөтөлбөрүүдээр байнга баяжиж байдаг “Cool Japan” хөтөлбөр нь аливаа улс орны ирээдүй болсон хүүхэд залууст илүү хүрч байгаа гэдэг утгаараа Япон улсыг сурталчлагч нэрийн хуудас-брэндийн үүргийг амжилттай гүйцэтгэсээр байх хандлагатай байна.

Онцгой ач холбогдол бүхий олон улсын чанартай соёл, хүмүүнлэг, урлаг спортын томоохон арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг өндөр түвшинд зохион байгуулахын зэрэгцээ тухайн арга хэмжээний үеэр оролцогч улсуудтай харилцах хамтын ажиллагаагаа шат ахиулах алхамуудыг амжилттай хийж ирсэн билээ. Тухайлбал :

2002 оны Япон Өмнөд Солонгосын хамтран зохион байгуулсан Хөлбөмбөгийн 17 дахь удаагийн ДАШТ-ний бэлтгэл ажлын хүрээнд өргөн хүрээний соёл урлаг, спортын арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлсэн нь тэмцээнийг амжилттай зохион байгуулахад төдийгүй хоёр орны цаашдын хамтын ажиллагаанд багагүй хувь нэмэр оруулсан байна. 2001 оны Кита Кюүшюү ЭКСПО, 2005 оны Айчи ЭКСПО зэрэг олон улсын үзэсгэлэнгүүдээс гадна тэмдэглэлт ойд зориулсан хөтөлбөрүүдийг дурдаж болох юм.

²⁴ Ministry of Foreign Affairs, Japan Diplomatic Bluebook 2006, p.208

²⁵ <http://www.mofa.go.jp/announce/fm/aso/speech0604-2.html> Speech by Taro Aso. A New Look at Cultural Diplomacy: A Call to Japan's Cultural Practitioners

²⁶ <http://www.mofa.go.jp/policy/culture/exchange/pop/manga/>

²⁷ www.mofa.go.jp/cultural/

2000 оноос хойш Гадаад Хэргийн Яамнаас тогтмол зохион байгуулах болсон тэмдэглэлт ойн хөтөлбөрүүд нь хоёр орны соёлын солилцооны олон талт үйл ажиллагаа явуулах замаар харилцан ойлголцлоо дээшлүүлэх, хамтран ажиллах шинэ шинэ боломжуудыг нээж хөгжүүлэхэд чиглэгдсэн байна. Тухайлбал : 2002 он Хятад- Японы хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой, 2003 он Япон АСЕАН-ний харилцааны жил, 2004 он АНУ-Японы харилцааны 150 жилийн ой, 2005 он Япон Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 150 жилийн ой, Япон-Солонгосын найрамдлын жил, 2006 он Япон-Австралийн солилцооны жил, Япон дахь Монголын жил, 2007 он Япон Энэтхэгийн солилцооны жил, 2008 он Япон Бразилийн солилцооны жил, Япон Индонезийн найрамдлын жил, 2009 он Япон-Дунай мөрний дагуух улсууд (Австри, Унгар, Румын, Болгар), Япон-Мекон мөрний дагуух улсууд (Тайланд, Вьетнам, Лаос, Мянмар, Камбож)-тай найрамдалт харилцааны жилийг тус тус тэмдэглэн өнгөрүүлжээ. 2005 он- Япон Европын жилийн хүрээнд нийт 1900 орчим соёл хүмүүнлэг, урлаг спортын арга хэмжээ болоод People-to-People солилцооны хөтөлбөрийг Европын 25 улстай хамтран зохион байгуулсан²⁸ нь Японы соёлын дипломат ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаагийн тод жишээ юм.

Соёлын дипломат ажиллагааны хүрээнд “Япон сан”-гийн хэрэгжүүлдэг томоохон ажлын нэр бол хилийн чанад дахь япон хэлний боловсролыг дэмжих явдал юм. “Япон сан” нь япон хэлний мэргэжилтнүүдийг гадаад улс орнуудад илгээх, гадаад орнуудын япон хэлний багш, оюутнуудад зориулсан мэргэжил дээшлүүлэх хэлний сургалт явуулах, япон хэлний сурах бичиг зохиох, хандивлах, ДТГ-уудаар дамжуулан япон хэлний уралдаан конкуре зохион байгуулах зэрэг ажлыг зохион байгуулдаг.

Япон хэлний боловсролыг дэмжих нь гадаад улсуудтай харилцах найрсаг харилцааг бататгах үндэс суурь болох төдийгүй тухайн орон Япон орны талаар үнэн зөв мэдээлэл өгөх, сурталчлан таниулах элч төлөөлөгчдийг бэлтгэж байгаа хэрэг юм. 2006 оны байдлаар дэлхийн 133 оронд япон хэлний 13 639 сургалтын байгууллагад 44 321 багш ажиллаж, 2 979 820 сурагцагч япон хэл судалж байсан бол 2009 оны судалгаагаар 14 925 сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж, 49 803 япон хэлний багш 3 651 232 суралцагчид япон хэл заадаг гэсэн тоо баримт гарсан байна.²⁹

Япон хэл судлах болсон шалтгааныг авч үзвэл Японд суралцах (35%), ажил хөдөлмөр эрхлэх (42,6%) зорилготой байсан бол сонирхолтой нь суралцагчдын ихэнх хэсэг нь японы поп соёл, анимэ, манга зэргийг сонирхон судлах (50,6%) болсонтой холбоотой³⁰ гэж Японы сангаас гаргасан 2009 оны судалгааны тайланд дурджээ.

Японы соёлын дипломат бодлогын салшгүй нэг хэсэг бол ЮНЕСКО – Японы хамтын ажиллагаа болон хөгжиж буй орнуудын соёлын өвийг хадгалах хамгаалах тусламжийн хөтөлбөр юм. Өнөөдөр Япон улс ЮНЕСКО-гийн төсвийг бүрдүүлэгч 2 дахь улс бөгөөд өнгөрсөн жилүүдэд, тухайлбал 2008-2010 онд 6 740 сая, 5 560 сая, 4,320 сая иений санхүүжилтийг³¹ харилцаа холбооны салбарт боловсрол, соёл, байгалийн шинжлэх ухаан, далай судлал гэх мэт байгалийн шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор тус тус үзүүлсэн байна.

Түүнчлэн Гадаад Хэргийн Яам, Аялал Жуулчлалын Газар хамтран “Японд зочлохуй” (Visit Japan) аялал жуулчлалын урт хугацааны компанит ажиллагааг жил бүр зохион байгуулдаг

²⁸Ministry of Foreign Affairs, Japan Diplomatic Bluebook 2006, p.216

²⁹<http://www.jpf.go.jp/e/japanese/survey/result/dl/2009/>

³⁰<http://www.jpf.go.jp/e/japanese/survey/result/dl/2009/>

³¹<http://www.mofa.go.jp/policy/culture/coop/unesco/outline.html>

бөгөөд Японы орны талаарх сурталчилгааг “Японд зочлохуй” цахим хуудсаар, гадаад орнуудын олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр, Элчин Сайдын Яамд, аялал жуулчлалын холбоо, эдийн засаг байгууллага, олон нийтийн байгууллагаас зохион байгуулах аливаа хурал цуглаан, уулзалт, сургалт, танилцах аялал болон соёлын бусад арга хэмжээгээр дамжуулан явуулдаг байна.³² Японд аялсан жуулчдын тоо 1980 онд 1 сая 317 мянга, 1990 онд 3 сая 236 мянга, 2000 онд 4 сая 757 мянга байсан бол 2010 онд 8 сая 611 мянга³³ болж эрс өссөн нь аялал жуулчлалын бодлого соёлын дипломат ажиллагаатай уялдан ажилласны үр дүн, “Cool Japan” хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаагийн илрэл юм.

Японы соёлын дипломат бодлогыг тодорхойлогч байгууллага нь Япон улсын Засгийн газар, Гадаад Хэргийн Яам бөгөөд хэрэгжүүлэгч гол байгууллага нь Гадаад Хэргийн Яамны Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газар, Соёл Боловсролын Яам, “Япон сан” болно. Мөн Гадаадын хэвлэлийн төв, Япон улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яамд, NHK телевиз радио, Аялал Жуулчлалын Газар түүний харъяа байгууллагууд, Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг дурдаж болно.

Эцэст нь Гадаад Хэргийн Яамнаас соёлын дипломат бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрүүдийг дурдвал :

- ✓ Япон улс цахим хуудас – Япон орны талаарх үндсэн мэдээллээр хангах зорилго бүхий web japan цахим хуудас.
- ✓ Японы соёлын сайн дурынхны хөтөлбөр
- ✓ Бүтээлч Япон хөтөлбөр
- ✓ Поп соёлын бодлого
- ✓ Япон хэлний боловсролын хөтөлбөр
- ✓ Япон хэл соёлын хөтөлбөр
- ✓ Япон судлал солилцооны хөтөлбөр
- ✓ “People-to-People” Иргэдийн солилцооны хөтөлбөр
- ✓ ЮНЕСКО, НҮБ гэх мэт олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах хөтөлбөрүүд
- ✓ Соёлын тэтгэлэгт хөтөлбөр
- ✓ “Япон сан”-гаас зохион байгуулдаг бусад хөтөлбөрүүд багтана. Засгийн Газрын авч хэрэгжүүлсэн тууштай, идэвхтэй соёлын дипломат бодлогын үр дүнг “BBC World Service” болон “World Public Opinion” олон улсын судалгааны төвөөс хамтран 2005 оноос хойш тогтмол явуулж байгаа улс гүрнүүдийн дэлхийн дахинд үзүүлэх нөлөө, нэр хүндийн талаар хийсэн санал асуулгын дүнгээс харж болно.

³² <http://www.jnto.go.jp/>

³³ http://www.jnto.go.jp/jpn/tourism_data/visitor_data.html

Views of Different Countries' Influence

Average of 27 Countries, 2011



*Average of 26 countries

Note: each aggregated rating excludes the target country's rating of itself, meaning some of the averages calculated are based on 26 and not 27 countries.


The white space in this chart represents "Depends," "Neither/neutral," and "DK/NA."

Asked of half of sample

2011 оны санал асуулгыг 2010-12-02 ны өдрөөс 2011-02-04-нийг хүртэл 27 орны 28,619 иргэний дунд интернет болон утсаар явуулсан байна.

Views of Japan's Influence

by Country, 2011



The white space in this chart represents "Depends," "Neither/neutral," and "DK/NA." Asked of half of sample

Зураг 1. 2011 оны III сард явуулсан санал асуулгын дүн.³⁴Зураг 2. Японы талаар өгсөн санал асуулгын дүн³⁵

2007 оны санал асуулгын дүнгээс харахад Япон улс 54%-ийн үзүүлэлттэй 2-р байранд, 2010 онд 53%-ийн үзүүлэлттэй мөн 2-р байранд жагсаж байсан бол 2011 онд 57%-ийн үзүүлэлттэйгээр 2-р байранд бичигдсэн байна. Судалгаанд оролцогсдын ихэнх нь Япон улсыг дэлхий дахины бодлогод эерэг нөлөө үзүүлдэг, нэр хүндтэй орон гэж үздэг байна.

Мөн түүнчлэн Японы улсын Гадаад Хэргийн Яам, Сингапурын TNS судалгааны төвтэй хамтран 2008 оны II-III сард Индонези, Малайз, Филиппин, Сингапур, Тайланд, Вьетнам орнуудын 1800 иргэний дунд Японы талаар санал асуулга явуулсан байна. Санал асуулгад оролцогсдын 44% нь Японыг АСЕАН-ы орнуудын хувьд итгэлтэй түнш, 49% нь зарим байдлаар найдвартай гэж үзсэн байна. Азийн хөгжил цэцэглэлтэнд оруулж буй Японы хувьд нэмрийг 43% нь маш идэвхтэй, 44% нь идэвхтэй дүгнэсэн байна.³⁶

³⁴ http://www.worldpublicopinion.org/pipa/pdf/mar11/BBCValsUS_Mar11_rpt.pdf p.28³⁵ http://www.worldpublicopinion.org/pipa/pdf/mar11/BBCValsUS_Mar11_rpt.pdf p.10³⁶ <http://www.mofa.go.jp/region/asia-paci/asean/survey/summary0803.pdf>

Онцлон дурдахад судалгаанд оролцогсдын 69% нь Японы соёлыг сонирхол татам гэж хариулжээ.

Курилын арлуудын асуудлаар байнгын маргаантай байдаг ОХУ-д 2010 оны III сард явуулсан санал асуулгын дүнгээр нийт оролцогсдын 90% нь ОХУ-Японы харилцаа гадаад бодлогод маш чухал, 73% нь хоёр орны харилцаа сайн, 41% нь Япон итгэлтэй түнш гэж хариулсан байна. Нэмж хэлэхэд Японы соёл урлаг (31%), шинжлэх ухаан, технологийн хөгжил (24%), түүх (22%) сонирхол татдаг гэж хариулсан байна.³⁷

2000 оноос эхлэн Японы эдийн засаг зогсонги байдалд орж, суларч эхэлсэн боловч соёлын дипломат бодлогод өндөр ач холбогдол өгч, амжилттай хэрэгжиж буй “Cool Japan” төсөл, тодорхой улс орнуудтай хамтран зохион байгуулдаг “тэмдэглэлт ой”, “найрамдлын жил”-ийн арга хэмжээнүүд болон хөгжиж буй орнуудад зориулсан соёлын тусламжийн хөтөлбөрүүдийг тасралтгүй хэрэгжүүлсээр ирсэн нь чамгүй үр дүнд хүрснийг дээр дурдсан санал асуулгын дүн бэлхнээ харуулж байна.

3. Японы соёлын дипломат ажиллагааны онцлог буюу дүгнэлт.

Японы соёлын дипломат ажиллагааны түүхэн тойм, орчин үеийн хөгжлийн чиг хандлагаас Японы соёлын дипломат ажиллагаа зорилго, чиглэл, онцлогийг дараах байдлаар дүгнэж болно.

1. Японы соёлын дипломат бодлогын үндсэн зорилго нь соёл, хүмүүнлэгийн олон талт хамтын ажиллагаагаар дамжуулан олон улсын тавцанд Япон улсын нэр хүнд, байр суурийг бататган бэхжүүлэх, гадаад таатай орчинг бүрдүүлэхэд оршино.

2. Японы соёлын дипломат ажиллагааны өнөөгийн чиг хандлага, үндсэн чиглэл нь

1) Өөрийн орны давуу тал болох үндэсний соёл, өв уламжлал болон шинжлэх ухаан, мэдээллийн технологийн ололтод тулгуурласан орчин үеийн урлагаар илэрхийлэгдэх өвөрмөц дүр төрхийг бүрдүүлж, гадаадад өөрийн орныг сурталчлан таниулах

2) Олон улсын хамтын нийгэмлэгүүдтэй хамтран ажиллаж, хариуцлагатай түнш, гол хандивлагчийн хувиар хөгжиж буй орнуудын соёлын тусламж үзүүлэх

3) Бүс нутаг төдийгүй дэлхий дахиныг хамарсан өргөн цар хүрээтэй, харилцан суралцсан, соёлын олон талт хамтын ажиллагааг идэвхтэй явуулах

4) Япон орны талаар үнэн, бодит мэдээллийг гадаадын иргэдэд хүргэж, сурталчлан таниулах элч төлөөлөгчдийг бэлтгэх үүднээс хилийн чанад дахь япон хэлний боловсролыг бүхий л талаар дэмжин ажиллах, Япон суралцах боломжоор хангах

5) Тодорхой бүс нутаг, улс орны онцлогийг харгалзсан зохистой болоод харилцан суралцсан соёлын солилцоог урт хугацааны төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулах зэрэг болно.

3. Япон улсын соёлын дипломат ажиллагааны онцлогуудыг дараах байдлаар тодорхойлж болно.

1) Зорилго, чиглэлийн хувьд залгамж шинж чанартай боловч цаг үеийн нөхцөл байдалд тохирсон, оновчтой, өргөн цар хүрээтэй шинэлэг бодлогуудыг боловсруулан урт хугацаанд, тасралтгүй баяжуулан хэрэгжүүлдэгээрээ онцлог юм.

2) Бүс нутаг, дэлхий дахины өмнө тулгарсан соёл боловсрол, хүмүүнлэгийн аливаа тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд гол хандивлагч, чадварлаг зохион байгуулагчийн хувиар идэвх санаачлагатай, манлайлах үүрэг рольтой оролцдог.

³⁷ http://www.mofa.go.jp/announce/announce/2010/7/0728_01.html

3) Өөрийн соёлыг зөвхөн сурталчлан таниулах биш гадаадын соёлоос суралцах, өөрийн орны иргэдэд сурталчлах, хөгжиж буй орнуудын соёлын өвийг сэргээх, хадгалан хамгаалахад чиглэсэн зэрэгцэн орших хамтын ажиллагаа явуулдаг нь Японы соёлын дипломат ажиллагааны нэгэн онцлог билээ.

4) Аливаа улс орны ирээдүй болсон хүүхэд залуусын анхаарал сонирхлыг татаж, тэднийг татан оролцуулж чадсанаараа Японы орчин үеийн соёлын дипломат ажиллагаа алсын хараатай, урт хугацааны үр дүнг агуулж чадсанаараа онцлог юм

5) Японы улсын Засгийн Газар төсвөөс чамгүй санхүүжилт олгодог нь соёлын дипломат ажиллагааг гадаад бодлогын салшгүй нэгэн хэсэг хэмээн өндрөөр үнэлэн, онцгойлон ач холбогдол өгдөгтэй холбоотой.

6) Соёлын дипломат ажиллагааг зөвхөн соёл, боловсрол, хүмүүнлэгийн салбарт бус эдийн засаг, аялал жуулчлал, байгаль орчин гэх мэт нийгмийн бүхий л салбарт хослуулан ашиглаж байна.

7) Мэдээлэл харилцааны технологийн хөгжил, интернэт өргөн тархснаар олони нийтийн санал бодол улс орны гадаад дотоод бодлогод тодорхой хэмжээгээр нөлөөлөх болсон өнөө үед соёлын дипломат ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлэхэд мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглаж байгааг Японы Гадаад Хэргийн Яамны цахим хуудас, “Японд зочлохуй” (Visit Japan) цахим хуудас зэргээс харж болно.

Эцэст нь дүгнэн хэлэхэд Японы соёлын дипломат ажиллагаа нь хөгжлийнхөө бүхий л шатанд идэвхтэй, амжилттай, үр дүнтэй хэрэгжиж ирсэн бөгөөд алсын хараатай, оновчтой, шинэлэг бодлогуудаараа дамжуулан “олон улсын тавцанд өөрийн орны нэр хүндийг өргөх, байр суурийг хадгалах” мөнхийн зорилгоо хэрэгжүүлсээр байгаа билээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. 金子将史。パブリックディプロマシー。PHP研究所。東京。2007年。
2. (Канеко Масаши, Олон нийтийн дипломат ажиллагаа, Токио хот, 2007 он)
3. Cummings.M, *Cultural Diplomacy and the United States Government: A survey*. Center for Arts and Culture, 2003
4. Kazuo Ogoura, *Japan's Postwar Cultural Diplomacy*, Center for Area Studies, Working Paper No1, 2008
5. Kazuo Ogoura, *Japan's Cultural Diplomacy :Past and Present*, JRIPEC, 2009
6. Peter J. Katzenstein, *Open Regionalism: Cultural Diplomacy and Popular Culture in Europe and Asia*, The American Political Science Association Annual Meeting Paper, 2002
7. Nancy Snow, Philip M. Taylor, *Routledge handbook of public diplomacy: Origin and Development of Japan's Public Diplomacy*, New York, 2009
8. Sang Mi Park. *Wartime Japan's Cultural Diplomacy and the Establishment of Culture Bureaus*. WIAS Discussion Paper, No 2008-2009
9. Ministry of Foreign Affairs, *Japan Diplomatic Bluebook 2000-2010*
10. Speech by Taro Aso. *A New Look at Cultural Diplomacy: A Call to Japan's Cultural Practitioners*
11. Peng Er Lam. *Japan's Quest for "Soft Power": Attraction and Limitation*, East Asia 2007, Vol. 24 pp. 349-363

12. Michal DALIOT-BUL, *Japan Brand Strategy: The Taming of 'Cool Japan' and the Challenges of Cultural Planning in a Postmodern Age*, Social Science Japan Journal 2009, Vol. 12, No. 2, pp 247–266, .
13. 佐々木 隆, 第 16 回 文化外交とは何 (Сасаки Такаши, Хичээл 16. Соёлын дипломат ажиллагаа гэж юу вэ? Цахим сургалт)
14. 안 엘리센. 신공공외교 : 국제관계와 소프트 파워. 서울, 2008년
15. (Jan Melissen, *The New Public Diplomacy: Soft power in International Relations*, солонгос хэлээр орчуулсан хувилбар)
16. 이수진, 패전이후 일본의 문화외교 전략성에 관한 연구-국제교류기금을 중심으로, 한양대학교 국제학대학원 國際學院友論集 8集 2011년 (И Сү Жин, Дайны дараах үеийн Японы соёлын дипломат ажиллагааны стратегитэй холбоотой судалгаа: “Япон сан” –гийн жишээн дээр. Ханяны их сургуулийн олон улсын харилцааны сургуулийн эрдэм шинжилгээний эмхэтгэл №8, 2011 он)
17. 채선영, 일본 문화외교에 관한 연구: 국제교류기금을 중심으로, 한신대학교 대학원 석사학위 논문. 2008 년 (Чэ Сон Ён, Японы соёлын дипломат ажиллагааны талаарх судалгаа : “Япон сан”-гийн жишээн дээр, Ханшин их сургуулийн магистрын зэрэг горилсон эрдэм шинжилгээний бүтээл 2008 он)
18. Цахим хуудас
19. <http://www.mofa.go.jp/> Япон улсын Гадаад Хэргийн Яамны цахим хуудас
20. <http://www.jpf.go.jp/> “Япон сан”-гийн цахим хуудас
21. <http://www.jnto.go.jp> Японы Аялал Жуулчлалын Газрын цахим хуудас
22. <http://www.bbc.co.uk/worldservice/>
23. <http://www.worldpublicopinion.org/>
24. <http://www.econfn.com/ssk/>